



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

᠑᠙᠑3 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 4᠘9᠐

Мандалговь

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2, Гамшгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоолоор баталсан “Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам” – ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Малын гоц халдварт Бог малын мялзан өвчний голомт үүссэн Адаацаг, Өлзийт, Гурвансайхан, Дэлгэрцогт, Сайхан-Овоо, Дэлгэрхангай, Луус, Сайнцагаан сумын нутаг дэвсгэрт хорио цээрийн дэглэм тогтоосноос 21 хоногийн хугацаанд өвчлөл дахиж бүртгэгдээгүй тул 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хорио цээрийн дэглэмийг хязгаарлалтын дэглэмд шилжүүлж 14 хоногийн хугацаатай тогтоосугай.

2. Хүн, амьтан, машин техник, малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж, хязгаарлалтын дэглэмийг чанд хэрэгжүүлэхийг Цагдаагийн газар (Б.Мөнхбат), нэгдсэн шуурхай удирдлагаар хангаж ажиллахыг Онцгой байдлын газар (Ц.Төрбилэг)-т даалгасугай.

3. Малын гоц халдварт өвчинтэй тэмцэх хариу арга хэмжээг мэргэжлийн арга зүйгээр хангаж үр дүнтэй зохион байгуулахыг Мал эмнэлгийн газар (И.Жавхлант)-т үүрэг болгосугай.

4. Хязгаарлалтын үед шаардагдах зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхтайван), захирамжийн хэрэгжилтийг хангуулж Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Х.Дашням)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4823100517